



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 5/50

Чингис хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.4, 26 дугаар зүйлийн 26.1, 26.1.1, 26.3 дахь заалт, Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам”-ын 3, 4, 5-ын “а”, 6, Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журмын 9.1, 10.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Д.Өнөрцэцэг нь албан бичгийн виз тойруулалгүй, хэлтсийн дарга нараар хянуулаагүй албан бичгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, аймгийн Засаг даргын 2 захирамж алдаатай гаргасан тул сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Өнөрцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР